



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/62/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16





**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Аодо 02.27 № 217

танай _____ -ны № _____ -т

ЧУЛУУНХОРООТ СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА Д.БАТТУЛГА
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520166



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн цалингийн зардлаас НДШ-ийн зардалд гүйлгэн зарцуулсан талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Чулуунхороот сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална” гэж тодорхойлсон байна.

Чулуунхороот сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах;
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь туслах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Чулуунхороот сумын ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Чулуунхороот сумын ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Aхplorer программ хангамж ашигладаг байна.

Чулуунхороот сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Чулуунхороот сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.



Аудитын төлөвлөлтийн үе шатанд 18 эрсдэлтэй асуудалд 18 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 424,827.9 мянган төгрөгөөс тооцон 8,496.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 9,573.0 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,330.7 мянган төгрөгөөр буюу 15.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,157.9	270.0	-1,887.9
Урьдчилгаа			
Бараа материал	151,024.9	158,690.8	7,665.9
Үндсэн хөрөнгө	809,356.8	965,425.4	156,068.6
Элэгдэл	-275,632.6	-332,148.4	-56,515.8
Нийт хөрөнгө	686,907.1	792,237.8	105,330.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	686,907.1	792,237.8	105,330.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	686,907.1	792,237.8	105,330.7

Авлага дансны үлдэгдэл буурсан нь оюутны сургалтын төлбөр 2,157.9 мянган төгрөгийн авлагаас 1887,9 мянган төгрөгийг цуглуулж авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материал, аж ахуйн материалын дансанд ХААГ-аас оготно устгалд зориулж багаж, нөөцийн өвс бэлтгэсэн зэрэгтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгө оруулалтаар болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө орлогод авсантай холбоотой байна. Хөрөнгө оруулалтаар 157,549.7 мянган төгрөг, өөрийн хөрөнгөөр 28,518.9 мянган төгрөгийн хөрөнгө авч нийт 186,068.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.



Дуусаагүй барилга байгууламжид байсан 30,000.0 мянган төгрөгийг халуун усны барилга ашиглалтад оруулан үндсэн хөрөнгөд шилжүүлсэн байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 792,237.8 мянган төгрөг болж 105,330.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Чулуунхороот сумын ЗДТГ нь тайлант онд 1,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 460.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 46.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	1,000.0	460.7	539.3	46.1
Нийт дүн	1,000.0	460.7	539.3	46.1

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 380,968.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 380,968.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 379,968.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 18 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 18 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 152,655.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 152,655.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. ЗДТГ-ын нөөцийн сангийн анхан шатны баримтыг тулган шалгахад журам зөрчин тэмцээн уралдаан, баяр ёслолын үйл ажиллагаанд 1,186.3 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн сангийн журам”-д хамаарахгүй Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэж заасантай нийцэхгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2. Тайлант хугацаанд хийсэн 151,469,3 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар



батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засаг даргын нөөцийн сангийн зарцуулалтад анхаарах.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Чулуунхороот сумын ЗДТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Чулуунхороот сумын ЗДТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 134 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдөж, тайлант онд 100 хувь биелсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалингийн зардлын талаар

1.1. Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг дахин хийн шалгахад цалингийн зардлаас НДШ-ийн зардалд 1,106.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсныг бүртгэлд зөрүүтэй тусгасан байна.

1.2. Эрсдэл: Тайлан баланс буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	153182947,22	158960774,00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0,00	0,00
33	АВЛАГА	2157991,20	270000,00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7991,20	0,00
335	Бусад авлага	2150000,00	270000,00
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2150000,00	270000,00
336	Зээлийн авлага	0,00	0,00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	0,00	0,00
35	БАРАА МАТЕРИАЛ	143421230,52	150673301,00
351	Түүхий эд материал	0,00	0,00
354	Хангамжийн материал	28608330,52	35860401,00
35410	Бичиг хэргийн материал	1232255,70	0,00
35420	Аж ахуйн материал	27376074,82	35687907,00
35470	Бусад хангамжийн материал	0,00	172494,00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	114812900,00	114812900,00
36	НӨӨЦИЙН БАРАА	7603725,50	8017473,00
36300	Тэжээлийн нөөц	7603725,50	8017473,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	533724184,75	633276994,95
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0,00	0,00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	533724184,75	633276994,95
391	Газар		
392	Биет хөрөнгө	527169184,81	626264175,59
39201	Барилга, байгууламж, орон сууц	115063116,63	243302812,63
39202	Хуримтлагдсан элэгдэл	0,00	-5476775,16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72444800,00	78294800,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-41117116,72	-46670833,48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	160495773,00	185625073,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92032364,41	-107933358,29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87605256,96	93339256,96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30390909,39	-37617582,99
39209	Зам, гүүрийн байгууламж	71837618,00	71837618,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-13930327,68	-20895491,52
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5600000,00	5600000,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	250625398,00	270525398,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-91108857,58	-106026939,56
39216	Дуусаагүй барилга, байгууламж	31000000,00	1000000,00
39217	Ном	1076798,00	1360198,00
393	Биет бус хөрөнгө	6554999,94	7012819,36
39301	Програм хангамж	10108050,00	11040250,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7053050,06	-7527430,64
39303	Бусад биет бус хөрөнгө	3500000,00	3500000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	686907131,97	792237768,95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0,00	0,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0,00	0,00
411	Богино хугацаат үнэт цаас	0,00	0,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	686907131,97	792237768,95
51	Засгийн газрын хувь оролцоо	686907131,97	792237768,95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	632079492,89	632079492,89



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	632079492,89	632079492,89
512	Хуримтлагдсан үр дүн	-38516000,83	66814636,15
51210	Өмнөх үеийн үр дүн	-38516000,83	-38516000,83
51220	Тайлант үеийн үр дүн	0,00	105330636,98
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	93343639,91	93343639,91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	686907131,97	792237768,95

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	437158850,00	613982230,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6550000,00	10800722,00
120	Нийтлэг татварын бус орлого	6550000,00	10800722,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6550000,00	10800722,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1100000,00	460722,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5450000,00	10340000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	430608850,00	603181508,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	36450000,00	157549696,00
131005	Хөрөнгийн санхүүжилт	36450000,00	157549696,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83710950,00	63172612,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81928450,00	61303734,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1782500,00	1868878,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	310447900,00	382459200,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	310447900,00	382459200,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	424827955,85	478651593,02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	400496005,85	478651593,02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399023135,72	451604885,27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197413123,78	212344613,57
210101	Үндсэн цалин	159156644,78	171279854,57
210105	Гэрээт ажлын хөлс	38256479,00	41064759,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24033151,69	27464252,38
210201	Тэтгэврийн даатгал	15372008,80	21813238,24
210202	Тэтгэмжийн даатгал	2700700,00	2246844,54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1614700,00	852374,51
210204	Ажилгүйдлийн даатгал	402599,82	291172,99
210205	Эрүүл мэндийн даатгал	3943143,07	2260622,10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6448986,50	6564837,00
210301	Гэрэл, цахилгаан	956226,00	1199104,00
210302	Түлш, халаалт	5492760,50	5365733,00
2104	Хангамж, бараа материалын зардал	31515222,50	58253015,62
210401	Бичиг хэрэг	2505900,00	4798530,70
210402	Тээвэр, шатахуун	23589140,00	36193754,60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3525400,00	8741400,00
210404	Ном, хэвлэл	0,00	6500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1104600,00	1689937,50
210408	Бараа материал акталсны зардал	790182,50	6822892,82
2105	Нормативт зардал	2076031,00	464100,00
210502	Хоол, хүнс	1929031,00	376100,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0,00	88000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2110000,00	9241200,00
210604	Урсгал засвар	2110000,00	9241200,00
2107	Томилолт, зочны зардал	2721900,00	5278000,00
210702	Дотоод албан томилолт	2721900,00	5278000,00



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2347090,20	1385378,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0,00	600000,00
210803	Даатгалын үйлчилгээ	100000,00	330390,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234000,00	399200,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100000,00	33000,00
210807	Газрын төлбөр	7515,20	22788,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130357630,05	130609488,70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63131186,00	74093702,90
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67226444,05	56515785,80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1472870,13	27046707,75
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1472870,13	27046707,75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1472870,13	27046707,75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12330894,15	135330636,98
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0,00	30000000,00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0,00	30000000,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0,00	-30000000,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12330894,15	105330636,98

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	395258850,00	446092534,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1100000,00	460722,00
120	Нийтлэг татварын бус орлого	1100000,00	460722,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1100000,00	460722,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1100000,00	460722,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394158850,00	445631812,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83710950,00	63172612,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81928450,00	61303734,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1782500,00	1868878,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	310447900,00	382459200,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	310447900,00	382459200,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	329823600,00	446092534,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329823600,00	446092534,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	328350729,87	419045826,25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197628015,78	212344613,57
210101	Үндсэн цалин	159156644,78	171279854,57
210105	Гэрээт ажлын хөлс	38471371,00	41064759,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24701142,89	27456261,18
210201	Тэтгэврийн даатгал	16040000,00	21805247,04
210202	Тэтгэмжийн даатгал	2700700,00	2246844,54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1614700,00	852374,51
210204	Ажилгүйдлийн даатгал	402599,82	291172,99
210205	Эрүүл мэндийн даатгал	3943143,07	2260622,10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5898967,50	7254168,50
210301	Гэрэл, цахилгаан	956226,00	1199104,00
210302	Түлш, халаалт	4942741,50	6055064,50
2104	Хангамж, бараа материалын зардал	30864040,00	50755516,00
210401	Бичиг хэрэг	2505900,00	3919250,00
210402	Тээвэр, шатахуун	23589140,00	34208666,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3525400,00	8741400,00
210404	Ном, хэвлэл	0,00	368400,00



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1243600,00	3517800,00
2105	Нормативт зардал	2376031,00	1979600,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000,00	1979600,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2110000,00	35174000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0,00	18659300,00
210602	Тавилга	0,00	5705000,00
210604	Урсгал засвар	2110000,00	10809700,00
2107	Томилолт, зочны зардал	2721900,00	5278000,00
210702	Дотоод албан томилолт	2721900,00	5278000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2347090,20	2317578,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0,00	600000,00
210803	Даатгалын үйлчилгээ	100000,00	330390,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234000,00	399200,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100000,00	33000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	177575,00	932200,00
210807	Газрын төлбөр	7515,20	22788,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59703542,50	76486089,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59703542,50	76486089,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1472870,13	27046707,75
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1472870,13	27046707,75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1472870,13	27046707,75

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	632 079 492,89	93 343 639,91	-38 516 000,83	0,00	686 907 131,97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	632 079 492,89	93 343 639,91	-38 516 000,83	0,00	686 907 131,97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00
C07	Тайлант үеийн үр дүн					0,00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	632 079 492,89	93 343 639,91	-38 516 000,83	0,00	686 907 131,97
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	632 079 492,89	93 343 639,91	-38 516 000,83	0,00	686 907 131,97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	632 079 492,89	93 343 639,91	-38 516 000,83	0,00	686 907 131,97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00	0,00
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	105 330 636,98	0,00	105 330 636,98
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	632 079 492,89	93 343 639,91	66 814 636,15	0,00	792 237 768,95



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	622895800,00	265971729,87	380968800,00	355873214,25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	578792500,00	265971729,87	380968800,00	355873214,25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267344600,00	265971729,87	380968800,00	355873214,25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198598300,00	197628015,78	231342000,00	212344613,57
210101	Үндсэн цалин	160123700,00	159156644,78	177342000,00	171279854,57
210105	Гэрээт ажлын хөлс	38474600,00	38471371,00	54000000,00	41064759,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24791700,00	24701142,89	31942200,00	27456261,18
210201	Тэтгэврийн даатгал	16040000,00	16752100,00	22891200,00	21805247,04
210202	Тэтгэмжийн даатгал	2700700,00	1990300,00	2300400,00	2246844,54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1615200,00	1623900,00	1802500,00	852374,51
210204	Ажилгүйдлийн даатгал	403500,00	402599,82	450500,00	291172,99
210205	Эрүүл мэндийн даатгал	4032300,00	3932243,07	4497600,00	2260622,10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6138500,00	5898967,50	8235400,00	7254168,50
210301	Гэрэл, цахилгаан	1138500,00	956226,00	2035500,00	1199104,00
210302	Түлш, халаалт	5000000,00	4942741,50	6199900,00	6055064,50
210303	Цэвэр, бохир ус	0,00	0,00	0,00	0,00
210304	Байрны түрээс	0,00	0,00	0,00	0,00
2104	Хангамж, бараа материалын зардал	23036600,00	23016771,00	49540300,00	47038507,00
210401	Бичиг хэрэг	2282000,00	2281900,00	3824100,00	3869750,00
210402	Тээвэр, шатахуун	16450000,00	16439971,00	32782200,00	30541157,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3504600,00	3495000,00	9093000,00	8741400,00
210404	Ном, хэвлэл	0,00	0,00	334000,00	368400,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800000,00	799900,00	3507000,00	3517800,00
2105	Нормативт зардал	300000,00	300000,00	1980300,00	1979600,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000,00	300000,00	1980300,00	1979600,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000,00	491000,00	35272000,00	35174000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл			11826700,00	18659300,00
210602	Тавилга			12635300,00	5705000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			0,00	0,00
210604	Урсгал засвар	500000,00	491000,00	10810000,00	10809700,00
2107	Томилолт, зочны зардал	2725500,00	2721900,00	5813900,00	5278000,00
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт	2725500,00	2721900,00	5813900,00	5278000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	634000,00	619090,20	2260400,00	2317578,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0,00	0,00	600000,00	600000,00
210803	Даатгалын үйлчилгээ	100000,00	100000,00	349700,00	330390,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234000,00	234000,00	205500,00	399200,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100000,00	100000,00	153000,00	33000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180000,00	177575,00	932200,00	932200,00
210807	Газрын төлбөр	20000,00	7515,20	20000,00	22788,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10620000,00	10594842,50	14582300,00	17030486,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10620000,00	10594842,50	14582300,00	17030486,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44103300,0	0,0	0,0	0,0



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2200	Дотоод эх үүсвэрээр	44103300,0	0,0	0,0	0,0
223001	Бусад хөрөнгө	44103300,00	0,00	0,00	0,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	311447900,00	311447900,00	380968800,00	380429522,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	311447900,00	311447900,00	380968800,00	262571922,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	310447900,0	310447900,0	379968800,00	379968800,00
132001	Орон нутгийн төсвөөс	310447900,0	310447900,0	379968800,00	379968800,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1000000,00	1000000,00	1000000,00	460722,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1000000,0	1000000,0	1000000,00	460722,00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0,00	0,00	0,00	0,00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0,00	0,00	0,00	0,00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1,00	1,00	1,00	1,00
610001	Төсвийн байгууллага	1,00	1,00	1,00	1,00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28,00	28,00	28,00	28,00
620001	Удирдах ажилтан	2,00	2,00	2,00	2,00
620002	Гүйцэтгэх ажилтан	16,00	16,00	16,00	16,00
620003	Үйлчлэх ажилтан	12,00	12,00	12,00	12,00
620004	Гэрээт ажилтан				